

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/152/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Дундманхайдай Аудит" ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт	19
4.1 Залруулсан алдаа.....	19
4.2 Төлбөрийн акт	19
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/183
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ц.АРИУНТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
D 2022/2022 Ч/А/АН/БН/СГ
19020555

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,626,486.99	32,188,017.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	1,700.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	1,700.00
3121	Төгрөг	00.00	1,700.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	1,700.00
33	АВЛАГА	1,785,462.00	291,980.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,493,482.00	00.00
335	Бусад авлага	291,980.00	291,980.00
3351	Байгууллагаас авах авлага	291,980.00	291,980.00
35	БАРАА МАТЕРИАЛ	23,841,024.99	31,894,337.36
351	Түүхий эд материал	6,432,485.09	11,341,883.46
35130	Эм боох материал	6,432,485.09	11,341,883.46
354	Хангамжийн материал	17,408,539.90	20,552,453.90
35410	Бичиг хэргийн материал	93,100.00	60,000.00
35420	Аж ахуйн материал	7,529,030.00	10,898,444.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,994,900.00	5,994,900.00
35450	Барилгын засварын материал	1,662,005.00	1,662,005.00
35460	Хүнсний материал	1,332,300.00	295,000.00
35470	Бусад хангамжийн материал	797,204.90	1,642,104.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	683,832,739.68	741,932,500.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	683,832,739.68	741,932,500.52
392	Биет хөрөнгө	682,604,739.68	740,704,500.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	630,123,432.78	673,123,432.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,214,564.94	-41,600,642.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	77,010,084.00	77,010,084.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-44,493,938.53	-55,716,221.01
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,912,528.00	91,374,578.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-11,443,787.84	-14,833,395.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,907,020.50	8,907,020.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,184,850.13	-7,252,850.05
39209	Зам, гүүрийн байгууламж	28,037,615.33	28,037,615.33
39210	Хуримтлагдсан элэгдэл	-22,152,057.52	-23,198,379.16
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,071,600.00	6,071,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-968,341.97	-1,218,341.93
393	Биет бус хөрөнгө	1,228,000.00	1,228,000.00
39301	Программ хангамж	50,000.00	50,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-50,000.00	-50,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,228,000.00	1,228,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	709,459,226.67	774,120,517.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,169,424.90	9,859,023.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,169,424.90	9,859,023.90
413	Өглөг	2,169,424.90	9,859,023.90
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,736,911.77	00.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	388,194.90	9,859,023.90
4136	Бусад өглөг	44,318.23	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	44,318.23	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>707,289,801.77</u>	<u>764,261,493.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	707,289,801.77	764,261,493.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	233,383,976.31	233,383,976.31
51101	Өмч: - төрийн	233,383,976.31	233,383,976.31
512	Хуримтлагдсан үр дүн	-29,015,791.80	27,955,900.41
51210	Өмнөх үеийн үр дүн	-29,015,791.80	-29,015,791.80
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	56,971,692.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	502,921,617.26	502,921,617.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>709,459,226.67</u>	<u>774,120,517.88</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
		/төгрөгөөр/	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	416,912,026.06	490,512,485.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,401,741.06	92,737,190.20
120	Нийтлэг татварын бус орлого	68,401,741.06	92,737,190.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,401,741.06	92,737,190.20
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	53,884,700.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	14,517,041.06	92,737,190.20
122	Тусламжийн орлого	00.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/		00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого		00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,510,285.00	76,270,695.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	289,013,300.00	321,504,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	289,013,300.00	321,504,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,893,825.00	24,424,155.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	980,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,913,825.00	24,424,155.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	38,068,900.00	38,505,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	38,068,900.00	38,505,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,534,260.00	13,341,340.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,534,260.00	13,341,340.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	369,949,053.69	433,540,792.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	369,949,053.69	433,540,792.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,476,730.48	433,221,206.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,071,081.23	261,399,163.00
210101	Үндсэн цалин	143,520,107.23	160,766,465.23
210102	Нэмэгдэл	66,559,155.00	72,372,497.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,323,924.00	3,998,000.00
210104	Урамшуулал	14,667,895.00	24,262,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,528,795.56	33,566,455.00
210201	Тэтгэврийн даатгал	19,966,897.35	23,543,514.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,234.98	2,511,240.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,716,867.98	2,003,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	426,826.99	500,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,267,968.26	5,007,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,364,997.00	35,210,614.00
210301	Гэрэл, цахилгаан	2,816,569.00	1,703,584.00
210302	Түлш, халаалт	30,548,428.00	33,432,030.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	75,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,099,689.30	31,374,780.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	1,604,250.00	2,807,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,612,800.00	20,730,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	260,100.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,418,500.00	750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,827,750.00	6,937,780.00
210408	Бараа материал акталсны зардал	376,289.30	00.00
2105	Нормативт зардал	27,018,896.01	28,154,350.83
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,362,796.01	21,299,820.83
210502	Хоол, хүнс	5,656,100.00	6,854,530.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,088,100.00	135,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		00.00
210604	Урсгал засвар	1,088,100.00	135,000.00
2107	Томилолт, зочны зардал	760,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	760,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	662,233.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,700.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	196,533.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,882,938.38	42,380,844.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	487,748.00	8,018,555.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,395,190.38	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		34,362,289.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,472,323.21	319,586.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,370,703.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,370,703.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,101,620.21	319,586.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,101,620.21	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>46,962,972.37</u>	<u>56,971,692.21</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	120,132.48	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	120,132.48	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-120,132.48	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>46,842,839.89</u>	<u>56,971,692.21</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	-24,547,163.56	711,758,430.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	-24,547,163.56	711,758,430.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,869,262.45	-1,869,262.45
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	-29,015,791.80	707,289,801.77
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	-29,015,791.80	707,289,801.77
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	-29,015,791.80	707,289,801.77
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	57,706,692.21	57,706,692.21
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	233,383,976.31	502,921,617.26	28,690,900.41	764,996,493.98

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	348,510,285.00	397,775,295.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	327,082,200.00	00.00
122	Тусламжийн орлого	38,154,100.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	288,928,100.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	288,928,100.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	21,428,085.00	397,775,295.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	321,504,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,893,825.00	24,424,155.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	980,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,913,825.00	24,424,155.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	38,505,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	38,505,200.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	14,534,260.00	13,341,340.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	14,534,260.00	13,341,340.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	348,633,485.00	397,208,195.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,633,485.00	397,208,195.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,161,161.79	396,888,609.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,071,081.23	248,873,465.23
210101	Үндсэн цалин	143,520,107.23	160,766,465.23
210102	Нэмэгдэл	66,559,155.00	59,846,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,323,924.00	3,998,000.00
210104	Урамшуулал	14,667,895.00	24,262,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,528,795.56	33,559,114.77
210201	Тэтгэврийн даатгал	19,966,897.35	23,543,514.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,150,234.98	2,503,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,716,867.98	2,003,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	426,826.99	500,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,267,968.26	5,007,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,664,997.00	37,035,614.00
210301	Гэрэл, цахилгаан	2,816,569.00	3,553,584.00
210302	Түлш, халаалт	30,548,428.00	33,432,030.00
210303	Цэвэр, бохир ус	300,000.00	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,984,800.00	23,829,100.00
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,512,100.00
210402	Тээвэр, шатахуун	21,084,800.00	20,730,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	837,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	750,000.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	12,846,625.00	17,184,260.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,733,525.00	11,531,350.00
210502	Хоол, хүнс	5,113,100.00	5,652,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,798,400.00	5,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,680,000.00	1,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000,000.00	2,750,000.00
210604	Урсгал засвар	1,118,400.00	1,150,000.00
2107	Томилолт, зочны зардал	760,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	760,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,662,233.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,033,700.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	196,533.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,844,230.00	29,907,055.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,844,230.00	29,907,055.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,472,323.21	319,586.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,370,703.00	319,586.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,370,703.00	319,586.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,101,620.21	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,101,620.21	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-123,200.00	567,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	565,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	565,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	565,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	565,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-565,400.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-123,200.00	1,700.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	123,200.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	1,700.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	377,838,200.0	373,029,854.0	4,808,346.0	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,838,200.0	373,029,854.0	4,808,346.0	98.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	377,838,200.0	373,029,854.0	4,808,346.0	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	250,393,100.0	248,873,465.2	1,519,634.8	99.4
210101	Үндсэн цалин	161,748,100.0	160,766,465.2	981,634.8	99.4
210102	Нэмэгдэл	59,846,800.0	59,846,800.0	-	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536,000.0	3,998,000.0	538,000.0	88.1
210104	Урамшуулал	24,262,200.0	24,262,200.0	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,803,200.0	33,559,114.8	244,085.2	99.3
210201	Тэтгэврийн даатгал	23,787,600.0	23,543,514.8	244,085.2	99.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,503,900.0	2,503,900.0	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,003,100.0	2,003,100.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	500,800.0	500,800.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,007,800.0	5,007,800.0	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,355,200.0	37,035,614.0	319,586.0	99.1
210301	Гэрэл, цахилгаан	3,555,200.0	3,553,584.0	1,616.0	100.0
210302	Түлш, халаалт	33,500,000.0	33,432,030.0	67,970.0	99.8
210303	Цэвэр, бохир ус	300,000.0	50,000.0	250,000.0	16.7
2104	Хангамж, бараа материалын зардал	24,630,000.0	23,829,100.0	800,900.0	96.7
210401	Бичиг хэрэг	1,500,000.0	1,512,100.0	(12,100.0)	100.8
210402	Тээвэр, шатахуун	20,730,000.0	20,730,000.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.0	837,000.0	63,000.0	93.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.0	750,000.0	750,000.0	50.0
2105	Нормативт зардал	19,106,700.0	17,184,260.0	1,922,440.0	89.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,106,700.0	11,531,350.0	575,350.0	95.2
210502	Хоол, хүнс	7,000,000.0	5,652,910.0	1,347,090.0	80.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,750,000.0	5,750,000.0	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.0	1,600,000.0	-	100.0
210602	Тавилга	3,000,000.0	3,000,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	1,150,000.0	1,150,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0	1,000,000.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.0	5,798,300.0	1,700.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,800,000.0	5,798,300.0	1,700.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	377,838,200.0	373,351,140.0	4,487,060.0	98.8

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	321,504,600.0	321,504,600.0	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,504,600.0	321,504,600.0	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,505,200.0	38,505,200.0	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	38,505,200.0	38,505,200.0	-	100.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,828,400.0	13,341,340.0	4,487,060.0	74.8
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,828,400.0	13,341,340.0	4,487,060.0	74.8
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.0	18.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.0	13.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.0	4.0	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/төгрөгөөр/
			Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	24,424,155.00	24,424,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,424,155.00	24,424,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,424,155.00	24,424,155.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,424,155.00	24,424,155.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,424,155.00	24,424,155.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	24,424,155.00	24,424,155.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,424,155.00	24,424,155.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,424,155.00	24,424,155.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет болон биет бус хөрөнгийг шийдвэрлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний аудитор Н.Тэмүүжин, туслах аудитор С.Ариунтунгалаг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр 2022 оны 02 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв нь бүхний эрүүл мэндийн төлөө хамтдаа зүтгэн, сумын эрүүл мэндийн төвийн стандартын хангалтыг сайжруулан, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, сумын иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхийг эрхэм зорилгоо болгон эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйлчилгээ явуулдаг байгууллага юм.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн эмнэлгийн бусад үйл ажиллагаа
- Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар томилогдсон дотоод хяналтын баг нь 2021 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө гарган батлуулж, дотоод үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын ажлын тайланг улирал бүр тайлагнасан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд дотоод аудитыг Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба хэрэгжүүлдэг. Тайлант онд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдсэн байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зардал 377,838.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,667.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4,250.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:

Тус байгууллага нь 2021 онд төсвөөс 377,838.2 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 373,351.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 98.8 хувийг авсан.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 24,424.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 397,208.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансанд 43,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 49,462.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 92,462.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 565.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 91,896.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 78,464.5 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 70,102.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 140,508.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Авлага, өглөгийн талаар:

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл 291.9 мянган төгрөгийн, 9,859.0 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Тус байгууллага нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн дансанд 1.7 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансны үлдэгдэлгүй байна. Бараа материал 31,894.3 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 741,932.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1.7	1.7
Авлага	1,785.5	292.0	(1,493.5)
Урьдчилгаа			-
Бараа материал	23,841.0	31,894.3	8,053.3
Үндсэн хөрөнгө	683,832.7	741,932.5	58,099.8
Нийт хөрөнгө	709,459.2	774,120.5	64,661.3
Өр төлбөр	2,169.4	9,859.0	7,689.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	707,289.8	764,261.5	56,971.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	709,459.2	774,120.5	64,661.3

Бараа материалын дансны үлдэгдэл 31,894.3 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 8,053.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 741,932.5 мянган төгрөг болж 58,099.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 764,261.5 мянган төгрөг болж 56,971.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 377,838.2 мянган төгрөгөөр төлөвлөн, бараа ажил үйлчилгээний зардалд 377,838.2 мянган төгрөг санхүүжүүлэхээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 377,838.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 321,504.6 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 38,505.2 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 13,341.3 мянган төгрөгийн, нийт 373,351.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 373,029.9 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, 319.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, зарцуулаагүй үлдэгдэл 1.7 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 373,029.9 мянган төгрөг буюу 98.7 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 24,425.2 мянган төгрөг төвлөрч, бараа үйлчилгээний бусад зардалд 24,424.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд 43,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 49,462.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 92,462.1 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 565.4 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 91,896.7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 31,894.3 мянган төгрөг байгаа нь Ковид-19 өвчний үед шаардлагатай эм бэлдмэл, хамгаалах хувцас хэрэглэл, ариутгалын бодисын бэлэн байдлыг хангах зорилгоор бараа материалын нөөц үүсгэсэн байна. Тайлант хугацаанд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлогыг хүлээн авсан даруй зарцуулж тайлагнасан, бараа материалын орлого, зарлагын бүртгэлийг бөөгнүүлж бүртгэж тайлагнаж байна.

Дэлгэрхаан сумын Эргэлтийн эмийн сан нь 51,770.1 мянган төгрөгийн эмийн борлуулалтын орлогыг и-баримтаар баталгаажуулаагүй, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 4,212.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон Коронавируст халдвар /Ковид-19/ -ын тусламж үйлчилгээний санхүүжилтийг хувийн хамгаалах хэрэгсэл, шаардлагатай эм, эмийн нөөц бэлтгэх, ариутгал халдваргүйжүүлэлт, өвчтөний хоол, улаан бүсэд ажилласан эмч, ажилчдын цалин зэрэгт зарцуулсан.

3.8 Аудитын гол асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 81 нэр төрлийн 54,313.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1 нэр төрлийн 50.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хий шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд шилэн дансанд 146 мэдээлэл мэдээлэхээс 121 мэдээллийг хугацаандаа, 25 мэдээллийг хугацаа хоцроосон төлөвтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1 алдаа зөрчил тайлант онд давтан гарч байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад анхаарал татах асуудал гараагүй ба дараагийн аудитаар үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого, зарлагын бүртгэлийг нягтлах, аудитаар бичигдсэн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 182,991.5 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 127,994.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 633.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 2 албан шаардлага хүргүүлж, 54,363.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад 127,994.1 мянган төгрөгийн 2 алдааг залруулав. Үүнд:

1. Тайлант хугацаанд ЭМЯ болон аймгийн ЭМГ-аас үнэ төлбөргүй олгосон 77,623.9 мянган төгрөгийн бараа материал, 1,658.0 мянган төгрөгийн хөрөнгө, нийт 79,281.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй олгосон орлогыг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаж тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.5-д бүх орлого" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудитлагдсан тайлантай тулгахад нийт үр дүн 48,712.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 633.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант хугацаанд 18 албан хаагчид вакцины урамшуулал цалин олгоходоо НДШ-ийг суутган тооцолгүй, зөвхөн ХХОАТ-ыг суутган тооцсоны улмаас гарт олгох урамшуулалт цалинг 409.9 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д "Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 1/Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цалин хөлс, мөн хуулийн 55, 56, 57, 59, 64, 66, 69 дүгээр зүйлд заасан олговор" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Тохиолдсон байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон урамшуулалт цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус ЭМТ-ийн даргын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар 3 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгохдоо даатгуулагчаас төлөх НДШ 63.3 мянган төгрөг, 48.7 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаагүй, гарт олгох цалинг 112.0 мянган төгрөгөөр илүү олгосон нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн илүү олгосон цалинг холбогдох албан хаагчдаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв. Үүнд:

1. ЭМТ-ийн даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/24 дугаар "Эд хөрөнгийн тооллогын комисс байгуулах тухай" тушаалаар тооллогын комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэй томилж тооллогыг гүйцэтгэсэн боловч тооллогын үр дүнг хэлэлцээгүй, баталгаажуулаагүй нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв бодитой гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс 121 мэдээллийг хугацаандаа, 25 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэх өртөггүй 81 нэр төрлийн 54,313.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 1 нэр төрлийн 50.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө тус тус бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-д "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг

төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн аудитын "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн биет болон биет бус хөрөнгийг шийдвэрлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газар болон "Дундманхайдай Аудит" ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв	7	182,991.5	2	127,994.1	2	633.7	2	-	1	54,363.7

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn